ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТЫН ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХАД ЧИГЛЭСЭН НЭМЭЛТ II ПРОТОКОЛ

Ерөнхий Ассамблейн 1989 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 44/128 тоот тогтоолоор батлав

Энэхүү протоколд оролцогч улс нь,

Цаазаар авах ялыг халах нь хүний нэр төр, эрхийг хамгаална гэдэгт итгэж,

1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйл болон 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 6 дугаар зүйлийг эргэн санаж,

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 6 дугаар зүйлд цаазаар авах ялыг халах нь талаар дурдаагүй тул цаазаар авах ялыг халах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж,

Цаазаар авах ялыг халахад чиглэсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хүний амьд явах эрхийг хангах баталгаа болох ёстойг ухамсарлаж,

Цаазаар авах ялыг халах үүргийг олон улсын өмнө хүлээхийг хүсэж,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов.

1 дүгээр зүйл

1. Энэхүү протоколд оролцогч улс цаазаар авах ялыг өөрийн шүүхийн харьяалалд хамаарах хэнд ч хэрэглэхгүй.

2. Оролцогч улс бүр өөрийн эрх хэмжээний хүрээнд цаазаар авах ялыг халахад чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авна.

2 дугаар зүйл

1. Дайны үед үйлдэгдсэн онц хүнд цэргийн гэмт хэрэгтэй холбоотойгоор Протоколыг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орох үед цаазаар авах ялыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд энэхүү протоколд тайлбар хийхгүй.

2. Ийм тайлбар хийж буй оролцогч улс нь энэхүү протоколыг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орох үедээ дайны үед хэрэглэгдэх өөрийн улсын хууль тогтоомжийн холбогдох заалтын талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх ёстой.

3. Ийм тайлбар хийсэн оролцогч улс нь өөрийн нутаг дэвсгэрт дайны байдал эхэлсэн буюу дууссан талаар Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх ёстой.

3 дугаар зүйл

Оролцогч улс нь Пактын 40 дүгээр зүйлд заасны дагуу Хүний эрхийн хороонд хүргүүлэх илтгэлд энэхүү протоколыг хэрэгжүүлэх зорилгоор авсан арга хэмжээний талаар тусгана.

4 дүгээр зүйл

41 дүгээр зүйлийн дагуу мэдэгдэл гаргасан Пактад нэгдэн орсон улсын нэг нь хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа талаар өөр нэг оролцогч улсаас гаргасан мэдээллийг, үүргээ биелүүлээгүй гэх тухайн улс энэхүү протоколыг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орох үед няцаасан мэдэгдэл хийснээс бусад тохиолдолд Хүний эрхийн хороо уг мэдээллийг хүлээн авч, хянан хэлэлцэхэд энэхүү протоколын заалтыг хэрэглэх эрхтэй.

5 дугаар зүйл

1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт I протоколд оролцогч улсын харьяат этгээдээс гаргасан мэдээллийг, тухайн оролцогч улс Протоколыг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орох үед няцаасан мэдэгдэл хийснээс бусад тохиолдолд Хүний эрхийн хороо уг мэдээллийг хүлээн авч, хянан хэлэлцэхэд энэхүү Ппротоколын заалтыг хэрэглэх эрхтэй.

6 дугаар зүйл

1. Энэхүү протоколын заалтууд нь Пактын нэмэлт заалт болон хэрэглэгдэнэ.

2. Энэхүү протоколын 2 дугаар зүйлд заасан тайлбар хийх боломжийг хөндөхгүйгээр энэхүү протоколын 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар баталгаажсан эрхээс Пактын 4 дүгээр зүйлийг үндэслэн татгалзаж болохгүй.

7 дугаар зүйл

1. Пактад гарын үсэг зурсан аль ч улсын хувьд энэхүү Протокол гарын үсэг зурах эрх нээлттэй.

2. Пактыг соёрхон баталсан аль ч улс энэхүү протоколыг соёрхон батална. Соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Пактад нэгдэн орсон аль ч улс энэхүү протокол нэгдэн орох эрх нээлттэй.

4. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичиг бүрийн талаар энэхүү протоколд гарын үсэг зурсан, эсхүл нэгдэн орсон бүх улсад мэдэгдэнэ.

8 дугаар зүйл

1. Энэхүү Протокол нь түүнийг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэн орсон тухай арав дахь баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсанаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон тухай арав дахь баримт бичгийг хадгалуулсанаас хойш энэхүү протоколыг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэн орсон улсын хувьд энэхүү протокол нь түүнийг соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон тухай өөрийн баримт бичгийг хадгалуулсанаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

9 дүгээр зүйл

Энэхүү протоколыг ямар нэг хязгаарлалт тогтоохгүй холбооны улсын нийт нутаг дэвсгэрт хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Пактын 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хамаарах бүх улсад дараахь мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:

(a) энэхүү протоколын 2 дугаар зүйлийн дагуу хийсэн тайлбар, мэдээлэл, мэдэгдэл;

(b) энэхүү протоколын 4 болон 5 дугаар зүйлийн дагуу хийсэн мэдэгдэл;

(c) энэхүү протоколын 7 дугаар зүйлийн дагуу гарын үсэг зурсан, соёрхон баталсан болон нэгдэн орсон тухай мэдээлэл;

(d) энэхүү протоколын 8 дугаар зүйлийн дагуу энэ протокол хүчин төгөлдөр болсон огноо.

11 дүгээр зүйл

1. Энэхүү протоколын араб, хятад, англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн эх бичвэр нь адил хүчинтэй байх бөгөөд эдгээрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын архивт хадгална.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү протоколын баталгаат хувийг Пактын 48 дугаар зүйлд заасан бүх улсад хүргүүлнэ.